



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Мөнхтөр)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Журам батлах тухай” А/141 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД



Ж.ЭНХБАЯР

152501000607

Тэргүүн Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025
оны 12-дугаар сарын 18-ны өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт
107

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь олон улсын өндөр чансаатай мэргэжлийн сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл, судалгааны ажлын үр дүнг боловсруулан туурвисан эрдэм шинжилгээний номыг сонгон шалгаруулж, дэмжлэг үзүүлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг дараах төрлөөр жил бүр сонгон шалгаруулна. Үүнд:

1.2.1. эрдэм шинжилгээний өгүүллийн төрөл /цаашид “өгүүлэл” гэх/, үүнд мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл /journal article/ болон хурлын эмхэтгэлд нийтлүүлсэн өгүүлэл /proceeding article/, номын бүлэг /book chapter/.

1.2.2. эрдэм шинжилгээний номын төрөл /цаашид “ном” гэх/, үүнд ном /book/, нэг сэдэвт бүтээл /monograph/ төрлийн бүтээлүүд багтана.

Хоёр. Бүтээлд тавигдах шаардлага

2.1. Эрдэм шинжилгээний бүтээл нь сонгон шалгаруулалт явагдах оноос өмнөх 2 жилийн хугацаанд нийтлэгдсэн байна.

2.2. Өгүүлэл нь Шпрингер Нэйчур (Springer Nature) хэвлэлийн газрын Дайменшз (Dimensions) мэдээллийн санд /цаашид мэдээллийн сан гэх/ бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүл, хурлын эмхэтгэлд нийтлэгдсэн байна.

2.3. Өгүүллийн зохиогч нь нэгдүгээр эсвэл холбоо барих зохиогч байх ба Монгол Улсад бүртгэлтэй байгууллагад харьяалагдах Монгол Улсын иргэн байна.

2.4. Нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор нийтлэгддэггүй салбарын өгүүлэлд журмын 2.3. дугаар заалт хамаарахгүй.

2.5. Ном нь 48-аас дээш хуудастай, ISBN дугаартай цаасан болон цахимаар хэвлэгдсэн бүтээл байна.

2.6. Номын зохиогч нь Монгол Улсын иргэн байна.

2.7. Орчуулгын болон дахин хэвлэсэн номыг сонгон шалгаруулалтад оруулахгүй.

Гурав. Шилдэг бүтээлд нэр дэвшүүлэх

3.1. Энэ журмын 1.2.1-д заасан шилдэг өгүүллийг шалгаруулахдаа мэдээллийн сангаас гаргадаг эшлэл, үр дүнгийн тайланд суурилж шалгаруулна.

3.2. Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, аж ахуйн нэгж, судлаачид сонгон шалгаруулалтад энэ журмын 1.2.2.-т заасан номыг нэр дэвшүүлж болно.

3.3. Дэвшүүлэх номыг дараах баримт бичгийн хамт шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

- 3.3.1. Энэ журмын 3 дугаар хавсралтаар баталсан нэр дэвшүүлэх маягт;
- 3.3.2. Номын танилцуулга, түүний редактор, зохиогч(ид) тус бүрийн товч танилцуулга, (нэг А4 хуудаснаас ихгүй);
- 3.3.3. Эрдэм шинжилгээний шилдэг номд дэвшүүлэхээр шийдвэрлэсэн эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр;
- 3.3.4. Эрдмийн зөвлөл байхгүй тохиолдолд бусад хамтран зохиогч тус бүрээс сонгон шалгаруулалтад дэвшүүлэхийг дэмжсэн зөвшөөрөл;
- 3.3.5. Зохиогчийн эрх эзэмшигчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэхийг дэмжсэн зөвшөөрөл;
- 3.3.6. Монгол Улсын Номын сангийн тухай хуулийн 17-р зүйлд заасны дагуу заавал өгөх хувийг Үндэсний номын санд хүлээлгэн өгсөн тухай лавлагаа;
- 3.3.7. Судалгааны төслийн хүрээнд хэвлэн нийтлэгдсэн номын хувьд төслийн талаарх мэдээлэл;
- 3.3.8. Хэвлэмэл номын хувь.

3.4. Шилдэг бүтээлийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийг буцааж олгохгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалт

4.1. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл болон шилдэг ном сонгон шалгаруулах комиссыг байгуулж тухайн оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

4.2. Комисс нь салбарын тэргүүлэх судлаачид, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 хүртэлх гишүүнтэй байна. Комиссын гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй байна.

4.3. Өгүүллийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Organisation for Economic Cooperation and Development)-аас ангилсан Шинжлэх ухааны үндсэн салбар тус бүрээр шалгаруулна. Үүнд:

- 4.3.1 анагаахын шинжлэх ухаан, эрүүл мэнд;
- 4.3.2 байгалийн ухаан;
- 4.3.3 инженерчлэл, технологи;
- 4.3.4 хөдөө аж ахуйн шинжлэх ухаан;
- 4.3.5 хүмүүнлэгийн ухаан;
- 4.3.6 нийгмийн шинжлэх ухаан.

4.4. Өгүүллийн сонгон шалгаруулалтыг дараах хоёр үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

4.4.1. Эхний шатанд энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангаж буй Салбартаа эшлэгдсэн байдал (Field Citation Ratio)-ын үзүүлэлт хамгийн өндөр гурван өгүүллийн урьдчилсан жагсаалтыг журмын 4.3-д заасан шинжлэх ухааны салбар тус бүрээр гаргана.

4.4.2. Хоёрдугаар шатанд урьдчилсан жагсаалтад багтсан өгүүлэл, зохиогчийн бүтээмжийг дараах үзүүлэлтээр Хавсралт 1-д заасан үнэлгээний хуудсаар үнэлнэ. Үүнд:

- Эрдэм шинжилгээний өгүүллийн нөлөөлөл;
- Зохиогчийн бүтээмжийн үзүүлэлт.

4.6. Энэхүү журмын шаардлагыг хангаж буй номыг дараах үзүүлэлтээр Хавсралт 2-т заасан үнэлгээний хуудсаар үнэлнэ. Үүнд:

- Номын бичилт, зохион байгуулалт, агуулгын чанар;
- Номын шинжлэх ухааны салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол;
- Сэдвийн судлагдсан байдал;
- Шинэлэг байдал, ашиглаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал;
- Номын дүгнэлт, утга санааны ойлгомжтой байдал;
- Номын өгүүлбэр зүй, бичилт;
- Номын үзэмж, хэвлэлийн чанар, дизайн;

4.6.1. Олон улсын номын сангийн индекс бүхий мэдээллийн санд бүртгэлтэй бол давуу тал болно. Үүнд: Web of Science, Scopus, Dimensions, бусад.

4.7. Комиссын хурлаар бүтээлд гишүүдийн өгсөн үнэлгээг танилцуулж үнэлгээг нэгтгэн, шилдэг бүтээлийг шалгаруулна.

4.8. Гишүүдээс өгсөн үнэлгээ тэнцсэн тохиолдолд санал хураалтаар шийдвэрлэнэ. Хуралд оролцсон гишүүдийн олонхын санал авсан бүтээлийг шилдэг бүтээлээр шалгаруулна. Комиссын хурал 80-аас доошгүй хувийн ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.

4.9. Комиссын дүгнэлтийг үндэслэн шинжлэх ухааны салбар тус бүрд хамгийн өндөр үнэлгээ авсан шилдэг өгүүлэл нийтлүүлсэн судлаач, шилдэг ном хэвлүүлсэн зохиогч бүрд бүтээл хэвлүүлэх зардалд 10.0 (арав) сая төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.

4.10. Шилдэг бүтээлийн дэмжлэгийг нэг бүтээлд нэг удаа олгоно.

Тав. Бусад

5.1. Шилдэг бүтээлийг батламжлах, олон нийтэд алдаршуулах арга хэмжээг жил бүрийн Шинжлэх ухааны ажилтны өдөр зохион байгуулна.

5.2. Шилдэг бүтээл шалгаруулах үйл ажиллагаа болон дэмжлэг үзүүлэхтэй холбогдох зардлыг Шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас гаргана.

5.3. Судлаачийг харьяалах байгууллагаас нь давхар урамшуулах асуудал энэхүү журамд хамаарахгүй болно.

5.4. Бүтээл нь Хэвлэлийн ёс зүйн хорооны (Committee on Publication Ethics) дүрэм, журмаар ёс зүйн зөрчилгүй байх ба цаашид гарах ёс зүй хариуцлагыг судлаач өөрөө бүрэн хариуцна.

---o0o---

Шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг үнэлэх хуудас

Бүтээлийн нэр:.....

DOI дугаар:.....

Зохиогч:

Мэдээллийн сангийн үзүүлэлтүүд	Үнэлгээ /1-3 оноо/
1. Эрдэм шинжилгээний өгүүллийн нөлөөлөл (Сонгон шалгаруулах 2 жилийн хугацаанд)	
1.1. Өгүүллийн салбартаа эшлэгдсэн байдал (Field Citation Ratio)	
1.2. Өгүүллийн эшлэгдсэн тоо	
2. Зохиогчийн бүтээмжийн үзүүлэлт* (Мэдээллийн санд бүртгэгдсэнээр)	
2.1. Зохиогчийн бүтээл (2.1-2.5 -ын дундаж)	
2.1.1. Нийт өгүүллийн тоо /articles/	
2.1.2. Нийт тойм өгүүлэл /reviews/	
2.1.3. Нийт хурлын өгүүлэл /proceedings/	
2.1.4. Нийт номын бүлэг /book chapters/	
2.1.5. Нийт тэмдэглэл /notes/	
2.1.6. Нийт захиа /letters/	
2.2. Нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн бүтээлийн нийт тоо*	
НИЙТ ҮНЭЛГЭЭ	

*Бүх бүтээлийн хувьд тооцох

Огноо:.....

Комиссын гишүүн:

Гарын үсэг:

Эрдэм шинжилгээний шилдэг
бүтээл шалгаруулах журмын
хоёрдугаар хавсралт

Шилдэг номыг үнэлэх хуудас

Бүтээлийн нэр:

ISBN дугаар:

Зохиогч:

	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ /1-3 оноо/
1	Номын бичилт, зохион байгуулалт, агуулгын чанар	
2	Номын шинжлэх ухааны салбарт оруулж буй хувь нэмэр, ач холбогдол	
3	Сэдвийн судлагдсан байдал	
4	Шинэлэг байдал болон ашиглаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал	
5	Номын дүгнэлт, утга санааны ойлгомжтой байдал	
6	Номын өгүүлбэр зүй, бичилт	
7	Номын үзэмж, хэвлэлийн чанар, дизайн	
8	Олон улсын номын сангийн индекс бүхий мэдээллийн санд бүртгэлтэй эсэх, үүнд: 8.1. Web of Science 8.2. Scopus 8.3. Dimensions 8.4. бусад	
НИЙТ ҮНЭЛГЭЭ		

Огноо:.....

Комиссын гишүүн:

Гарын үсэг:

Эрдэм шинжилгээний шилдэг
бүтээл шалгаруулах журмын
гуравдугаар хавсралт

**Эрдэм шинжилгээний шилдэг номыг
сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэх маягт**

Нэр дэвшүүлж буй байгууллага:

Зохигчийн мэдээлэл:

Овог, нэр:

Харьяалах байгууллага:

Утасны дугаар:

Цахим шуудангийн хаяг:

Бүтээлийн нэр, ISBN дугаар:

.....

.....

Баримт бичгийн бүрдэл, тус бүр 3 хувь:

- Номын танилцуулга болон түүний редактор, зохиогч(ид) тус бүрийн товч танилцуулга, (нэг А4 хуудаснаас ихгүй);
- Эрдэм шинжилгээний шилдэг номд дэвшүүлэхээр шийдвэрлэсэн эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр;
- Эрдмийн зөвлөл байхгүй тохиолдолд бусад хамтран зохиогч тус бүрээс сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэхийг дэмжсэн зөвшөөрөл;
- Зохиогчийн эрх эзэмшигчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэхийг дэмжсэн зөвшөөрөл;
- Монгол Улсын Номын сангийн тухай хуулийн 17-р зүйлд заасны дагуу заавал өгөх хувийг Үндэсний номын санд хүлээлгэн өгсөн тухай лавлагаа;
- Судалгааны төслийн хүрээнд хэвлэн нийтлэгдсэн номын хувьд төслийн талаарх мэдээлэл;
- Номын хэвлэмэл хувь.

Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журмын дагуу холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэн дээрх нэр бүхий бүтээлийг сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлж байна. Тус бүтээл нь зохиогчийн эрхийн зөрчилгүй болно.

Нэр дэвшүүлсэн байгууллагыг төлөөлж:

Албан тушаал:

Овог, нэр:

Гарын үсэг:

Огноо: